



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/441

Хэрлэн сум

“Чингис фестиваль-2023” соёлын биет бус  
өвийн их наадмыг зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Соёлын бүтээлч, үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Чингис хотод зохион байгуулагдах “Чингис фестиваль - 2023 “ соёлын биет бус өвийн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлийн хэсгийн дарга:	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Зулбаатар	Соёл урлагийн газрын дарга
Гишүүд:	Н.Зоригтбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	С.Оюун-Эрдэнэ	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Цогт-Эрдэнэ	Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга
	Д.Бат-Эрдэнэ	Хэрлэн сумын Засаг даргын орлогч
	Д.Баатарцогт	Соёл урлагийн газрын соёл урлагийн хэлтсийн дарга

Т.Отгонтуяа

Нийтийн номын сангийн  
захирлын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

Н.Нямсүрэн

Аймгийн музейн захирал

Т.Болд


“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Хэнтий  
цахилгаан түгээх сүлжээний  
дарга

Д.Батхуяг

Аймгийн Зураач урчуудын  
холбооны тэргүүн, зураач  
(тохиролцсоноор)

2.“Чингис фестиваль - 2023” соёлын биет бус өвийн их наадмыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ЧОГСОМЖАВ